



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ



**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

2020 он

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах Аудитор Ц.Батсайхан Аудитор Б.Анхтуяа 2020 оны 12 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй • 1.1 Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг ТЭЗҮ-ийн хамтад нь боловсруулаагүй, бүрэн нэгтгээгүй байна..... 7 • 1.1.1 Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг ТЭЗҮ-тэй хамтад нь боловсруулаагүй байна..... 7 • 1.1.2 Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг бүрэн нэгтгээгүй байна. 7 • 1.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хуулийн дагуу хүргүүлсэн боловч төлөвлөгөөний өөрчлөлтийг мэдээлсэн хугацаа тодорхойгүй байна. 9 • 1.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хуулийн дагуу хүргүүлсэн байна. 9 • 1.2.2 ТЭЗ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хуулийн хугацаанд мэдээлсэн эсэх тодорхойгүй байна..... 9 • 2.1 Захиалагч бүх тендерийг цахимаар зарласан боловч техникийн тодорхойлолт шаардлага хангаагүй байна..... 10 • 2.1.1 Захиалагчид худалдан авах ажиллагааг 2018 онд 97.4%, 2019 онд 100% цахим хэлбэрээр зарласан нь ил, тод өрсөлдөх тэгш боломжийг бүрдүүлсэн байна..... 10 • 2.1.2 Үнэлгээний хороог зохих журмын дагуу байгуулж байгаа боловч төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийн оролцоо хангалтгүй байна. 12 • 2.1.3 Үнэлгээний хороо захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. 12 • 2.2 Гүйцэтгэгчийг хууль журмын дагуу сонгоогүй байна..... 14 • 2.2.1 Тендерт ирүүлсэн бичиг баримтыг тендерийн үнэлгээний заавар маягтуудын дагуу үнэн зөв үнэлээгүй байна..... 14 • 2.2.2 Гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна. 15 • 3.1 Худалдан авах ажиллагааг журмын дагуу тайлагнасан байна..... 17 • 3.1.1 Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендерт шалгаруулалтын хавтаст хэргийг дутуу бүрдүүлсэн байна..... 17 • 3.1.2 Захиалагчид худалдан авах ажиллагааг тогтоосон хугацаанд нь холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнасан байна. 17 • 3.1.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна..... 17 • 3.2 2018-2019 оны худалдан авах ажиллагаанд ТЭЗ болон бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна. 17
--	--

	• 3.2.1 Орон нутгийн удирдлага хууль тогтоомжоор хүлээсэн хяналт тавих эрхээ бүрэн хэрэгжүүлээгүй байна..... 17 • 3.2.2 Эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна..... 18
	Дүгнэлт
	Зөвлөмж
	Холбогдох байгууллагын санал
	Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар
	Хавсралтууд

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
ААЗС	Аймгийн авто замын сан
АЗД	Аймгийн засаг дарга
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТББ	Төрийн бус байгууллага
ТОӨЗ	Тендерт оролцохын өмнөх зааварчилгаа
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/53 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Нийцлийн аудитыг хийлээ.

2. Аудитын зорилт:

Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд Нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

2. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газрын 2018-2019 оны худалдан авах ажиллагааны анхан шатны баримтууд, төлөвлөгөө, тайлан, холбогдох бусад баримт материалуудыг хамруулан мэдээ, судалгаанд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБООУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан аудитын төлөвлөгөөний арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг нягтлан шалгах, нөхцөл байдлын шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, тайлбар тодруулга, асуулга авах, түүвэр хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын төлөвлөгөөнд аудитын явцад нэмэлт, өөрчлөлт оруулсан болно.

5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр үе шатны хяналтыг хийж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Анхтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Монгол Улсад үүсээд байгаа Covid 19 цар тахлын улмаас 2020.11.11-нээс 2020.12.01-ний өдөр хүртэл Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт

шилжүүлсэн, улс даяар хөл хорионы хатуу дэглэм тогтоосонтой холбоотой аудитын хугацаа хойшлогдсон болно.

8. Үндсэн мэдээлэл

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2018 онд нийт 2,955,263.1 мянган төгрөгийн 35 ажлын, 21,100,740.6 мянган төгрөгийн 75 ажлын худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулсан байна.

Тухайлбал: 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 750.0 мянган төгрөгийн 2 ажил, Улсын төсвийн болон тусгай шилжүүлгийн байгууллагын 660,731.2 мянган төгрөгийн 12 ажил, АОНХС-гийн 1,214,002.4 мянган төгрөгийн 15 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 160,704.0 мянган төгрөгийн 1 ажил, БХНСАХЗ-ын 169,825.5 мянган төгрөгийн 5 ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнээс 32 тендерийг цахимаар, 3 тендерийг уламжлалт хэлбэрээр зарлаж, Зөвлөх үйлчилгээгээр 4, НТШ-аар 9, ХА-22 ажлын тендерийг шалгаруулсан байна.

2019 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 19,159,100.0 мянган төгрөгийн 23 ажил, Улсын төсвийн болон тусгай шилжүүлгийн байгууллагын 1,094,800.4 мянган төгрөгийн 22 ажил, АОНХС-гийн 246,420.3 мянган төгрөгийн 3 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 471,321.2 мянган төгрөгийн 21 ажил, БХНСАХЗ-ын 108,098.7 мянган төгрөгийн 5 ажил, АЗС-ын 21,000.0 мянган төгрөгийн 1 ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Үүнээс 69 тендерийг цахимаар, 6 тендерийг уламжлалт хэлбэрээр зарлаж, Зөвлөх үйлчилгээгээр 5, НТШ-аар 30, ХА-34, ШХА-6 ажлын тендерийг шалгаруулсан байна.

Бүлэг 1

Худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу төлөвлөгдөөгүй байна.


1.1 Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг ТЭЗҮ-ийн хамтад нь боловсруулаагүй, бүрэн нэгтгээгүй байна.

1.1.1 Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг ТЭЗҮ-тэй хамтад нь боловсруулаагүй байна.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2-т заасны дагуу ТЕЗ-ийн төсвийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг аймгийн ОНӨГ нэгтгэн гаргадаг ба харьяа байгууллагуудын албан бичгээр хандсан төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэмж төлөвлөгөөнд оруулж, ТЕЗ баталдаг байна.

ТЕЗ-ийн ХАА-ны 2018-2019 оны төлөвлөгөөнд ТЭЗҮ гаргуулаагүй нийт 42 төсөл, арга хэмжээг ТШЗ нараас ирүүлсэн саналыг үндэслэн тусгасан байна. Тухайлбал: 2018 онд 20, 2019 онд 22 төсөл, арга хэмжээг тус тус тусгажээ.

Дүрслэл 1



Дүрслэлээс харахад: Улсын төсвийн урсгал төсвөөр санхүүжигдэх 2018 онд 12, 2019 онд 22, орон нутгийн урсгал төсвөөр санхүүжигдэх 1, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжигдэх 7 арга хэмжээний санал ирүүлж төлөвлөгөөнд тус тус тусгасан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2, 2.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.


Иймд захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол ТЭЗҮ-ийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй нь хамтад нь боловсруулах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.2 Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг бүрэн нэгтгээгүй байна.

2018 онд нийт 3,335,835.6 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 62, 2019 онд нийт 21,635,979.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 102 бараа, ажил, үйлчилгээг худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

2018 оны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилбал:


Дүрслэл 2



Дүрслэлээс харахад: Аймгийн ОНХС 42% буюу 1,383,877.9 мянга, улсын төсвийн хөрөнгө оруулалт 22% буюу 750,000.0 мянга, улсын төсвийн урсгал төсөв 20% буюу 660,731.2 мянга, сумдын ОНХС 11% буюу 380,522.5 мянга, орон нутгийн урсгал төсөв 5% буюу 160,704.0 мянган төгрөг байна.

2019 оны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилбал:

Дүрслэл 3



Дүрслэлээс харахад: Улсын төсвийн хөрөнгө оруулалт 88.6% буюу 19,159,100.0 мянга, улсын төсвийн урсгал төсөв 5.1% буюу 1,094,800.4 мянга, Орон нутгийн хөрөнгө оруулалт 2.2% буюу 471,321. мянга, АОНХС 1.1% буюу 246,420.3 мянга, Авто замын сан 0.1% буюу 21,000.0 мянга, БХНСАХЗ-д 0.5% буюу 108,098.7 мянга, БОАЖГ-ын урсгал төсөв 0.1% буюу 26,000.0 мянга, "Ус-Ду" ОНӨААТҮГ-ын төсөв 0.2% буюу 33,000.0 мянга, Сумдын ОНХС 2.2% буюу 476,238.4 мянган төгрөг байна.

Аймгийн ОНӨГ нь өөрийн харьяа төсөвт бүх байгууллага, 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын тухайн онд худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг бүрэн нэгтгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2, 2.4 2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд ТЕЗ нь өөрийн харьяа төсөвт бүх байгууллага, 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын тухайн онд худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг бүрэн нэгтгэж, батлах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хуулийн дагуу хүргүүлсэн боловч төлөвлөгөөний өөрчлөлтийг мэдээлсэн хугацаа тодорхойгүй байна.

1.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хуулийн дагуу хүргүүлсэн байна.

ТЕЗ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-т заасны дагуу төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор төлөвлөгөөг баталж, Сангийн яаманд хүргүүлж цахимаар батлуулдаг байна. Төлөвлөгөөнд өөрчлөлт орсон хугацааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Төлөвлөгөөнд өөрчлөлт орсон огноо	Бараа, ажил, үйлчилгээний тоо	Батлагдсан төсөвт өртөг
2018		
1 дүгээр сарын 5	15	1,471,190.4
3 дугаар сарын 20	30	2,348,528.4
5 дугаар сарын 28	36	2,978,313.4
9 дүгээр сарын 28	37	2,955,313.1
2019		
1 дүгээр сарын 29	55	8,363,358.0
3 дугаар сарын 04	62	18,678,159.4
5 дугаар сарын 08	64	18,725,406.0
6 дугаар сарын 24	69	21,119,740.5
10 дугаар сарын 14	75	21,100,740.5

Хүснэгтээс харахад: 2018 оны ХАА-ны төлөвлөгөөг 2017 оны 12 дугаар сарын 21-нд баталсан ба 771,190.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 14 бараа, ажил, үйлчилгээг төлөвлөсөн боловч аймгийн ОНӨГ нь худалдан авах бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахаар 2018 онд 4 удаа Сангийн яаманд албан бичиг хүргүүлж, нийт 62 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр ХАА-ны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна.

2019 оны ХАА-ны төлөвлөгөөг 2018 оны 12 дугаар сарын 18-нд баталсан ба 1,322,313.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 34 бараа, ажил, үйлчилгээг төлөвлөсөн боловч худалдан авах бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахаар 2019 онд 5 удаа Сангийн яаманд албан бичиг хүргүүлсэн байна.


Сумын ТТЗ нар нь худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах саналыг аймгийн ОНӨГ-т нэгтгүүлээгүй, Сангийн яаманд бие даан хүргүүлдэг байна.

1.2.2 ТЕЗ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хуулийн хугацаанд мэдээлсэн эсэх тодорхойгүй байна.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-т “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дараах хэлбэрээр олон нийтэд байршуулсан байна.

Дүрслэл 4



Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг өөрчилж батлуулах бүр төрийн худалдан авах ажиллагааны /tender.gov.mn/ цахим хуудсанд өөрчлөлт оруулан батлуулж, үр дүнг нь ил тод нийтэлдэг байна. Ил тод нийтэлсний дараа тендер зарлах эрх үүсдэг байна.

2018, 2019 оны ХАА-ны төлөвлөгөөг олон нийтэд мэдээлсэн эсэхийг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- ✚ Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд төлөвлөгөөг байршуулсан боловч байршуулсан огноо тодорхойгүй
- ✚ Төлөвлөгөөг аймгийн болон ОНӨГ-ын цахим хуудсанд байршуулсан гэсэн боловч архивлагдаагүй
- ✚ 2019 онд Политехник коллежийн оюутан суралцагчдын хоолонд шаардагдах хуурай хүнсний төсвийг 5,000.0 мянга, хүнсний ногооны төсвийг 14,000.0 мянга нийт 19,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан

Иймд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн болон өөрийн цахим хуудсанд архив үүсгэж, төсвийг үнэн зөв байршуулах талаар аймгийн ОНӨГ-т зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх

Бүлэг 2

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад техникийн тодорхойлолт шаардлага хангаагүй, гүйцэтгэгчийг оновчтой сонгон шалгаруулаагүй байна.

2.1 Захиалагч бүх тендерийг цахимаар зарласан боловч техникийн тодорхойлолт шаардлага хангаагүй байна.

2.1.1 Захиалагчид худалдан авах ажиллагааг 2018 онд 97.4%, 2019 онд 100% цахим хэлбэрээр зарласан нь ил, тод өрсөлдөх тэгш боломжийг бүрдүүлсэн байна.

2018 онд төлөвлөсөн 62 бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ба төлөвлөгөөний биелэлт 98.4% буюу 1 ажил дараа онд шилжиж, зарлагдаагүй байна байна. Үүнд:

- ✚ Сумын ОНХС-гийн санхүүжилтээр хийгдэх 16,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй зураг төсөв хийх зөвлөх үйлчилгээний ажлын тоо хэмжээ тодорхой бус шалтгаанаар зарлагдаагүй байна.

ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан 2018 оны 61, 2019 оны 102 бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтын аргыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтад заасан босго үнийг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмын дагуу сонгосон байна. Тухайлбал:

Дүрслэл 5



Дүрслэлээс харахад: 2019 оны ХАА-ны сонгон шалгаруулалтыг өмнөх онтой харьцуулахад НТШ-ын арга 20 буюу 64.5%-иар, харьцуулалтын арга 18 буюу 40.9 %-иар, зөвлөх үйлчилгээг 2 буюу 28.6%-иар, шууд худалдан авах хэлбэрээр 1 буюу 5%-иар тус тус өссөн байна.

2019 оны төлөвлөсөн 102 бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг 100% зохион байгуулсан ба 2018 онд нийт 40 бараа, ажил, үйлчилгээг цахим хэлбэрээр зарлахаар төлөвлөснөөс 38 буюу 97.4%-ийг цахим хэлбэрээр зарлаж, 1 төсөл, арга хэмжээг уламжлалт хэлбэрээр, 1 зөвлөх үйлчилгээ зарлагдаагүй дараа онд шилжсэн, байна. Тухайлбал 2018 онд :

- ✚ Аймгийн болон Сүмбэр сумын Засаг даргын төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагаа цахим хэлбэрээр 100 хувь
- ✚ Шивээговь сумын Засаг даргын төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагаа цахим хэлбэрээр 50%, уламжлалт 1, 1 зөвлөх үйлчилгээ дараа онд шилжсэн
- ✚ Баянтал сумын Засаг даргын төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагаа шууд худалдан авалтаар хийгдсэн

ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан огноо, тендер шалгаруулалт явагдсан огноог харьцуулахад 2018 онд 13, 2019 онд 49 тендер худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд зохион байгуулагдаагүй бөгөөд хугацаа хоцорсон байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1, 2-оос үзнэ үү/

Иймд төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалтыг зохион байгуулах талаар аймгийн ОНӨГ-т зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 21 дүгээр зүйлд Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх талаар заасан байна.

2018, 2019 онд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаанаас түүврийн аргаар сонгон орон нутгийн урсгал төсөв, аймгийн ОНХС-гаар хийгдсэн худалдан авах ажиллагааны тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлсэн талаар тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ✚ 2018 онд “Боржигин чуулгад зөөврийн угсардаг тайз, дэлгэц худалдан авах” тендерийн урилгын огноог өөрийн цахим хуудсанд нийтлэхдээ 2017.09.21 гэж андуурч бичсэн
- ✚ 2019 онд “Авто замын их засварын ажил”-ын тендерийн урилгыг сонинд нийтлэхдээ тендер нээх огноог 2019.05.11 гэж зөрүүтэй бичсэн

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид тендерийн урилга зарлан мэдээлсэн огноог үнэн зөв тусгах талаар аймгийн ОНӨГ-т зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.1.2 Үнэлгээний хороог зохих журмын дагуу байгуулж байгаа боловч төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийн оролцоо хангалтгүй байна.

АЗД-ын захирамжаар 2018 онд 35, 2019 онд 51, нийт 86 үнэлгээний хороог байгуулсан ба үнэлгээний хороог хуулийн дагуу байгуулсан эсэхийг тулган баталгаажуулахад хувийн хэвшил, ИТХ-аас сонгогдсон төлөөлөгч, ТББ-ын төлөөллийг оролцуулсан 16, бусад төрийн байгууллагын албан хаагчдыг оролцуулсан 70 үнэлгээний хороо байгуулагдсан байна. Тухайлбал: 2018-2019 онд байгуулагдсан нийт 86 үнэлгээний хорооны 81.4%-д нь хувийн хэвшил, ИТХ-аас сонгогдсон төлөөлөгч, ТББ-ын төлөөллийг оролцуулаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.2, 47.3, 47.4, 47.6 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Хуулийн 47.4-д *“Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн эсхүл төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилсон иргэн, Засаг даргын тамгын газрын ажилтныг оролцуулна”* гэж заасан байна.

Гэвч Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл үнэлгээний хороонд орж ажиллахгүй байгаа нь хуулийн 47.6-д *“Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна”* гэсэн нөхцөл шаардлагыг хангахгүй байх, Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3.10-т заасны дагуу *“Үнэлгээний хороонд ажилласан иргэн, хувийн хэвшлийн төлөөлөлд ажилласан цагаар нь тооцож урамшуулал олгож болно”* гэж заасан боловч төсөв батлагдаж ирдэггүйгээс иргэд, иргэний нийгмийн төлөөлөл үнэлгээний хороонд ажиллах сонирхолгүй байдаг байна.

Иймд ТЕЗ нь Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг хууль журмын дагуу үнэлгээний хороонд оролцуулахад анхаарч, нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.1.3 Үнэлгээний хороо захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 11 дүгээр зүйлд захиалагчийн техникийн тодорхойлолтыг бэлтгэх шаардлагууд, 19 дүгээр зүйлд тендерийн бичиг баримт бэлтгэх талаар тус тус заасан байна.

Үнэлгээний хорооны гишүүд тендерт оролцохын өмнөх зааварчилгааны дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж, хянан захиалагчид хүргүүлэх ба захиалагч хуульд заасны дагуу хянан баталдаг байна.

Захиалагч үнэлгээний хороонд техникийн тодорхойлолтыг шууд баталсан хэлбэрээр ирүүлж, үнэлгээний хороо захиалагчийн баталж ирүүлсэн техникийн тодорхойлолтод үндэслэж тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж тендер шалгаруулалт хийгдсэн “Татварын хэлтсийн барилга”-ын техникийн тодорхойлолтыг захиалагч буюу аймгийн Засаг даргын Тамгын газраас боловсруулсан бөгөөд техникийн тодорхойлолтод ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11.1.3-т “барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй;” 11.1.4-т “энэ хуулийн 11.1.3-т заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэх” гэж заасныг зөрчсөн байна.

Татварын хэлтсийн барилгыг худалдан авалт хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд энэ нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэсэн боловч өрсөлдөөнийг хязгаарлаж, цорын ганц оролцогчийг сонгон шалгаруулах нөхцөл байдалд хүргэсэн байна. Тухайлбал:

Говьсүмбэр аймагт үйлчилгээний зориулалтаар баригдсан өөр барилга байгаагүй, техникийн тодорхойлолтод дүйцэхүйц гэсэн тодотгол хэрэглээгүй, барилгын талбайг 760м²-аас багагүй байх гэсэн бол “Сүмбэр буянт” ХХК-ний ирүүлсэн тендерийн баримтад талбайг 761м² гэж заасан зэргээс харахад өрсөлдөөнийг хязгаарласан байх нөхцөл байдал ажиглагдаж байна. Энэ талаар “Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”-нд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсан байна. Тендер шалгаруулалтыг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 6



Дүрслэлээс харахад: 2018 онд 17, 2019 онд 20 тендер шалгаруулалт амжилтгүй болж бүх тендерээс татгалзсан ба 2018 онд 5 буюу 29.4%, 2019 онд 6 буюу 30% компаниуд материал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй, 2018 онд 12 буюу 70.6%, 2019 онд 14 буюу 70.0% нэг ч компани тендер шалгаруулалтад оролцоогүй байна

2018 онд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаанаас түүврийн аргаар сонгон улсын болон орон нутгийн урсгал төсөв, аймгийн ОНХС-гаар хийгдсэн нийт 36 худалдан авах ажиллагааны тендерийн бичиг баримт, техникийн тодорхойлолтыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- “Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” 60,478.8 мянган төгрөгийн

төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолт шаардлага хангаагүй буюу барааны нэр төрлийг заасан

- “Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн хэрэгцээнд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” 67,729.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолт шаардлага хангаагүй буюу барааны нэр төрөл заасан
- “ШШГА-ны 75 айлын орон сууцны гадна фасад засварын ажил”-ын тендер шалгаруулалтыг анх зарлахад нэг ч компани оролцоогүй, дахин зарлахдаа ажлын тоо хэмжээг багасгаж, техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулсан
- “Цэргийн алдар хөшөөний тохижилтын ажил”-ын тендер шалгаруулалтыг анх зарлахад шаардлагад нийцсэн компани шалгараагүй, дахин зарлахдаа техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулсан боловч дахин шаардлагад нийцсэн компани оролцоогүй
- Харьцуулалтын аргаар зохион байгуулсан нийт 12 тендерт 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэх заалтыг ашиглаагүй,

2019 онд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаанаас түүврийн аргаар сонгон улсын болон орон нутгийн урсгал төсөв, аймаг, сумдын ОНХС-гаар хийгдсэн нийт 51 худалдан авах ажиллагааны тендерийн бичиг баримт, техникийн тодорхойлолтыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- “Аймгийн төвийн авто замын зураг /1.4 км/”, “Нэгдсэн эмнэлгийн хэрэгцээнд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх”, “Цэргийн алдар хөшөөний тохижилтын ажлын үргэлжлэл” нийт 3 ажлын тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулаагүй тендерийг зарласан
- Харьцуулалтын аргаар зохион байгуулсан нийт 22 тендерт 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэх заалтыг ашиглаагүй

Тендер шалгаруулалтын 44 гаруй хувь нь амжилтгүй, нэг ч компани оролцохгүй байгаа, оролцсон боловч материал шаардлага хангахгүй байгаа шалтгааныг ХАА-ны мэргэжилтнээс тодруулахад *“техникийн тодорхойлолтын нөхцөл шаардлага хэт өндөр, стандарт шаардлага, тоо хэмжээ их буюу төсвөөс хэтэрснээс болж тендер шалгаруулалт амжилтгүй болох нөхцөл бүрддэг, тендер шалгаруулалтад оролцож байгаа ААНБ-ууд хуулийн ойлголтгүй, ТШӨХ-ийн шалгуурыг сайтар хянаж тендерийн баримт бичгийг бэлдээгүй байдаг”* гэж хариулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.1.3, 33 дугаар зүйлийн 33.2, 47 дугаар зүйлийн 47.2.1, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд үнэлгээний хороо нь тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтыг захиалагчийн шаардлагыг бүрэн хангасан, өрсөлдөөнийг дэмжсэн, хуульд нийцсэн байх зарчмыг баримталж бэлтгэх талаар аймгийн ОНӨГ-т зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2 Гүйцэтгэгчийг хууль журмын дагуу сонгоогүй байна.

2.2.1 Тендерт ирүүлсэн бичиг баримтыг тендерийн үнэлгээний заавар маягтуудын дагуу үнэн зөв үнэлээгүй байна.

Тендерт ирүүлсэн оролцогч байгууллагуудын баримт бичгийг тендерт оролцохын өмнөх зааварчилгаа болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан

шаардлагуудын дагуу үнэлгээний хорооны гишүүд үнэлж захиалагчид зөвлөмж, дүгнэлт, тайланг хүргүүлдэг байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үйл ажиллагаанаас түүврийн аргаар сонгон орон нутгийн урсгал төсөв, аймгийн ОНХС-гаар хийгдсэн ажлуудаас 2018 онд 36, 2019 онд 51 худалдан авах ажиллагааны үнэлгээг тус тус тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ✚ 2 тендерт нээлтийн болон үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд гишүүд гарын үсэг зураагүй, дутуу зурсан
- ✚ 1 тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийн бүртгэлд үнийн саналыг андуурч бичсэн
- ✚ Журмын дагуу хөтөлдөг маягт 11-т шалгарсан байгууллагын нэр болон тендер шалгаруулалтад сонгосон аргыг андуурч бичсэн
- ✚ 5 тендерт оролцсон үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын мэдэгдэл гаргаагүй
- ✚ Тендер шалгаруулалт амжилтгүй болж тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж дахин зарлахдаа техникийн тодорхойлолтыг өөрчлөөгүй 4 тендерийг дахин зарласан
- ✚ Тендерийг хянан үзэх хүснэгтээр үнэлгээний хорооны гишүүд тендерийг бүрэн үнэлээгүй байна. Тухайлбал: Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн спорт заалны шалны ажилд 1 гишүүн нь үнэлээгүй, Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх ажилд 3 гишүүн, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх ажлын бүх гишүүд үнэлээгүй байна.


Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1, 30.4.2, 47 дугаар зүйлийн 47.8, Сангийн сайдын 2012 оны 194 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”-ын 1, 4, 6, 11 дүгээр маягтуудыг хөтлөөгүй, зааврыг зөрчсөн байна.

Иймд үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд гишүүд бүрэн гарын үсэг зурсан байх, тендерийн үнэлгээний заавар маягтуудыг үнэн зөв хөтлөх талаар аймгийн ОНӨГ-т зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.2 Гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.

Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийн дагуу босго үнэ, бараа, ажил, үйлчилгээ зэргээс нь хамаарч ТШӨХ, ТӨӨЗ-нд үндэслэн хянан үзэх хүснэгтийг боловсруулж үнэлгээний хорооны гишүүд ирүүлсэн материалыг хянан үзэх ба захиалагчийн зүгээс ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2-т заасны дагуу хяналт тавьж, үнэлгээний хорооноос гаргасан шийдвэрийг хянан баталгаажуулдаг байна. Тендер шалгаруулалтыг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 7



Дүрслэлээс харахад: 2018 онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 26, харьцуулалтын аргаар 11, зөвлөх үйлчилгээг сонгох аргаар 5, нийт 42 бараа, ажил, үйлчилгээ нийт тендер шалгаруулалтыг зохион байгуулсан ба 19 буюу 45.2% нь амжилттай зохион байгуулагдсан байна.

2019 онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 31, харьцуулалтын аргаар 44, зөвлөх

үйлчилгээг сонгох аргаар 7, нийт 82 бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулсан ба 62 буюу 75.6% нь амжилттай зохион байгуулагдсан байна.

2018-2019 онуудад зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаанаас түүврийн аргаар сонгон орон нутгийн урсгал төсөв, аймгийн ОНХС-гаар хийгдсэн нийт 87 худалдан авах ажиллагааны баримтуудыг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. Захиалагчид тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж дахин зарлах зөвлөмж хүргүүлсэн байхад захиалагч дахин зарлуулах хүсэлт ОНӨГ-т ирүүлээгүйгээс нийт 4 нээлттэй тендер шалгаруулалт дахин зарлаагүй байна. Үүнд / “Политехник коллежийн үйлдвэр сургалтын дадлагын материал нийлүүлэх ажил”, “Нэгдсэн эмнэлгийн хэрэгцээнд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх”, “Сүмбэр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн дотуур байрны сурагчдын хоол хүнсний материал нийлүүлэх”, “Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх” /
2. Нийт 10 тендерт шалгаруулалтын гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуульд заасан шаардлагуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.3, 27.4, 30 дугаар зүйлийн 30.4.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Иймд зохион байгуулагдсан тендер шалгаруулалтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлагууд мөрдөж ажиллахыг аймгийн ОНӨГ-т зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Худалдан авах ажиллагааг журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх

Бүлэг 3

Худалдан авах ажиллагааг журмын дагуу тайлагнасан боловч хяналт хийгдээгүй байна.

3.1 Худалдан авах ажиллагааг журмын дагуу тайлагнасан байна.

3.1.1 Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендерт шалгаруулалтын хавтаст хэргийг дутуу бүрдүүлсэн байна.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2-т “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэж заасны дагуу ОНӨГ нь 2018, 2019 онд улсын төсөв, урсгал төсөв, орон нутгийн урсгал төсөв, аймгийн ОНХС-гийн санхүүжилтээр хийгдсэн нийт 118 тендер шалгаруулалтыг цаасаар болон цахимаар хавтаст хэрэг болгон архивын нэгж болгон хадгалсан байна.

Гэвч тендерийн хавтаст хэрэгт гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичгийг дутуу бүрдүүлсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд захиалагч тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт гэрээ дүгнэж, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан баримт бичгийг бүрдүүлж байх аймгийн ОНӨГ-т зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.1.2 Захиалагчид худалдан авах ажиллагааг тогтоосон хугацаанд нь холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнасан байна.

Аймгийн ОНӨГ-аас 2018, 2019 онд Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан журмын 3.1.1, 3.1.2-т заасны дагуу ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны тайланг журамд заасан 9 маягтын дагуу 07 дугаар сарын 15-нд, бүтэн жилээр дараа оны 01 дүгээр сарын 15-нд Сангийн яаманд, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус тайлагнасан байна.

АЗДТГ-т худалдан авах ажиллагааны сар бүрийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг сар бүрийн 25-нд 3 маягтын дагуу хүргүүлдэг бөгөөд 2018 онд АЗДТГ-т хүргүүлсэн тайлан мэдээнд нийт 8 тендерийн зохион байгуулагдсан хугацааг буруу тайлагнасан байна.

Цаашид холбогдох газруудад хүргүүлж буй тайлан мэдээний үнэн зөв байдлыг хангаж ажиллах талаар аймгийн ОНӨГ-т зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.1.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 2018-2019 онд нийт 27 мэдээллийг бүрэн мэдээлсэн боловч 2018 онд 14.8% буюу 4, 2019 онд 7.4% буюу 2 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 2018-2019 оны худалдан авах ажиллагаанд ТЕЗ болон бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.2.1 Орон нутгийн удирдлага хууль тогтоомжоор хүлээсэн хяналт тавих эрхээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8-т “Хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах”, 14.2.10-т “өөрийн

эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасны дагуу ТЕЗ нь 2018, 2019 онд бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд аймгийн Засаг даргад дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2.2 Эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 4-т “худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх” гэж заасан байна. Үүний дагуу Сангийн яамнаас аймгийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг жил бүр үнэлдэг ба 2018 онд 83.3 хувь буюу “Сайн”, 2019 онд 80.0 хувь “Сайн” гэж тус тус үнэлэгдсэн байна.

2018, 2019 онд бусад эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Нийцлийн аудитаар илэрсэн 229,045.3 мянган төгрөгийн зөрчилд алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 10 зөвлөмж хүргүүллээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

- Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг ТЭЗҮ-ийн хамтад нь боловсруулаагүй, бүрэн нэгтгээгүй байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хуулийн дагуу хүргүүлсэн боловч хуулийн хугацаанд мэдээлсэн эсэх нь тодорхойгүй байна.

Бүлэг -2

- Захиалагчид худалдан авах ажиллагааг 2018 онд 97.4%, 2019 онд 100% цахим хэлбэрээр зарласан байна.
- Үнэлгээний хороог зохих журмын дагуу байгуулж байгаа боловч төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийн оролцоо хангалтгүй байна.
- Үнэлгээний хороо захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.
- Тендерт ирүүлсэн бичиг баримтыг журам зааврын дагуу үнэн зөв үнэлээгүй байна.
- Гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.

Бүлэг -3

- Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж хадгалсан байна.
- Захиалагчид худалдан авах ажиллагааг тогтоосон хугацаанд нь холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнасан байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна.
- Орон нутгийн удирдлага хууль тогтоомжоор хүлээсэн хяналт тавих эрхээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Г.Батзам танаа:

1. Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг ТЭЗҮ-ийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй нь хамтад нь боловсруулах
2. Өөрийн харьяа төсөвт бүх байгууллага, 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын тухайн онд худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг бүрэн нэгтгэж, батлах
3. Үнэлгээний хороог байгуулахдаа хууль журмын дагуу Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг үнэлгээний хороонд оролцуулахад анхаарч, нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах
4. Төсвийн тухай хуульд заасны дагуу хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллах

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батцэцэг танаа:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн болон өөрийн цахим хуудсанд архив үүсгэж, төсвийг үнэн зөв байршуулах
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, тендерийн урилга зарлан мэдээлсэн огноог үнэн зөв тусгах
3. Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтыг захиалагчийн шаардлагыг бүрэн хангасан, өрсөлдөөнийг дэмжсэн, хуульд нийцсэн байх зарчмыг баримталж бэлтгэх
4. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд гишүүд бүрэн гарын үсэг зурсан байх, тендерийн үнэлгээний заавар маягтуудыг үнэн зөв бөглөх
5. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлагуудыг мөрдөж ажиллах.
6. Захиалагч тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт гэрээ дүгнэж, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан баримт бичгийг бүрдүүлж байх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Нутгийн удирдлагын ордон 319 тоот,
Утас/Факс: (976) 7054 3033,
И-мэйл: goviumber.onug@gmail.com

2020.12.10 № 390
Тусгай 2020.12.08 -ны № 337 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Б.САРАНТУЯА ТАНАА

Төрийн аудитын хуулиар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд "Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийгдсэн Нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой ямар нэг санал байхгүй байна.

ДАРГА-г Б.САРАНТУЯА Д.БАТЦЭЦЭГ



20.12.10
Самсгал тайлан
аруудын, тайлан
гатаалгааны
дүнг 2020

4220300880

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан холбогдох байгууллагаас санал ирээгүй болно.

ХАВСРАЛТ:

Хавсралт 1

ХАА-ны нэр	Төлөвлөгөөнд тусгагдсан огноо	Тендер шалгаруулалт явагдсан огноо
3 ба 8-р байрны дундах тоглоомын талбайн тохижилтын ажил	2018.02.05-2018.02.20	2018.07.09-2018.07.20
ШШГА-ны 75 айлын орон сууцны гадна фасад засварын ажил	2018.02.05-2018.02.20	2018.07.05-2018.07.23
ТЗ-ын 1-р багт нийтийн бие засах газар байгуулах, зөөврийн хогийн сав байршуулах ажил	2018.03.05-2018.03.23	2018.03.28-2018.04.09
Найрамдал хотхоны орон сууцны гаднах зүлэгжүүлсэн талбайг хашаажуулах ажил	2018.02.19-2018.03.07	2018.03.28-2018.04.16
Авто замын дагуух ойн зурваст услалтын систем, ус нөөцлөх сав суурилуулах ажил	2018.02.19-2018.03.07	2018.04.27-2018.05.08
Аймгийн биологийн төрөл зүйлийн судалгаанд үндэслэн фото зургийн цомог хийлгэх ажил /амьтан, ургамал/	2018.02.26-2018.03.14	2018.05.29-2018.06.05
Тусгай хамгаалалттай газар нутаг болон аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах цэг байгуулах ажил	2018.02.19-2018.03.07	2018.05.29-2018.06.05
Гол горхи, булаг шандын эхийг хамгаалж, тохижуулах, хөв цөөрөм байгуулах	2018.02.19-2018.03.07	2018.07.06-2018.07.18
Боржигин чуулгад зөөврийн угсардаг тайз, дэлгэц худалдан авах	2018.06.04-2018.06.13	2018.09.21-2018.10.29
Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын ажил	2018.06.22-2018.07.06	2018.09.17-2018.09.25
Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлах зорилгоор мод усалгааны усны нөөц сав суурилуулах ажил	2018.05.30-2018.06.15	2018.09.14-2018.10.01
Нийтийн эзэмшлийн явган замын ажил	2018.05.30-2018.06.15	2018.09.14-2018.09.28
2019 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийн ажил	2018.06.27-2018.08.17	2018.11.12-2018.12.24

Д/д	Ажлын нэр	Төлөвлөгөөнд тусгагдсан огноо	Тендер шалгаруулалт явагдсан огноо
1	Шивээговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол хүнс	2019.05.27	6/6/2019
2	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т хог тээвэрлэх автомашин худалдан авах	2019.03.14	3/6/2019
3	Политехник коллежийн оюутан суралцагчдын хоолонд шаардагдах мах, махан бүтээгдэхүүн	2019.02.27	2/12/2019
4	Политехник коллежийн оюутан суралцагчдын хоолонд шаардагдах хуурай хүнс	2019.02.27	2/12/2019
5	Политехник коллежийн оюутан суралцагчдын хоолонд шаардагдах хүнсний ногоо	2019.02.27	2/12/2019
6	Политехник коллежийн үйлдвэр сургалтын дадлагын материал	2019.02.27	2/12/2019
7	Шивээговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөр	2019.05.27	2/13/2019
8	Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үдийн цай хөтөлбөр	2019.05.27	5/13/2019
9	Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах /Сүмбэр/	2019.02.13	2/11/2019
10	Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах /Шивээговь/	2019.02.13	2/11/2019
11	Нэгдсэн эмнэлгийн хэрэгцээнд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх	2019.07.04	2/22/2019
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих ангид шатах тослох материал нийлүүлэх	2019.05.27	2/25/2019
13	Сүмбэр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн дотуур байрны сурагчдын хоол хүнсний материал нийлүүлэх	2019.07.25 2019.08.28	3/11/2019
14	Сүмбэр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн үдийн цай хөтөлбөр	2019.07.01	3/11/2019
15	Цэргийн алдар хөшөөний тохижилтын ажлын үргэлжлэл	2019.07.05	3/4/2019
16	Авто замын их засварын ажил, Авто замын засварын ажил	2019.03.29 2019.05.09	3/4/2019
17	Боловсролын байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2019.05.07	2/14/2019
18	Аялал жуулчлалын түр буудаллах цэг байгуулах ажил	2019.04.09	3/4/2019
19	Баянтал сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайд гэрэлтүүлэг хийх ажил	2019.05.06	3/1/2019
20	Баянтал сумын 2-р багийн төвийн их засварын ажил	2019.04.09	3/1/2019
21	Цагдаагийн хэлтэст эргүүлийн автомашин худалдан авах	2019.03.14 2019.04.09	3/5/2019
22	Татварын хэлтэст автомашин худалдан авах	2019.03.29	3/5/2019
23	Боржигин морин хуур худалдан авах	2019.04.01	2/14/2019
24	Сүмбэр үүлдрийн хонины тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор "Цөм сүрэг үржлийн төв" ОНӨААТҮГ-азарт хонь худалдан авах	2015.05.24	5/13/2019
25	Төрийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авах	2019.02.12	2/14/2019
26	"Цэргийн алдар"-ын цэцэрлэгийн хамгаалалтын хашаа, хайс	2019..03.29	3/18/2019

27	Ойн зурвас байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх /хамгаалалтын торон хашаа суурилуулах 5 га/	2019.05.31	3/20/2019
28	Сум дундын ойн ангийн агротехникийн ажилд ашиглах тусгай зориулалтын жижиг оврын экскаватор худалдан авах	2019.03.28	3/20/2019
29	Агаар, орчны бохирдлын эх үүсвэрийг багасгаж бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах ажлын хүрээнд зөөврийн стандартын бие засах газар, хогийн сав худалдан авах	2019.05.31	3/20/2019
30	Аймгийн төвийн авто замд тэмдэг тэмдэглэгээ хийх ажил	2019.03.29	3/4/2019
31	Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнс	2019.07.01	6/6/2019
32	Сүмбэр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн үдийн цай хөтөлбөр	2019.05.27	3/11/2019
33	Хэлмэгдэгсдийн хөшөөний тохижилт, Сүмбэр сумын 5-р цэцэрлэгийн гадна зогсоолын ажил	2019.05.31	5/14/2019
34	Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх	2019.06.20 2019.07.22	5/30/2019
35	Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх	2019.05.27	6/3/2019
36	Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх	2019.05.27	6/3/2019
37	Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх	2019.09.16 2019.10.23	6/17/2019
38	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих ангид хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх	2019.05.29	5/22/2019
39	Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх	2019.08.29	7/8/2019
40	"Цэргийн алдар" хөшөөний модлог ургамлын цэцэрлэгийн хамгаалалтын хашаа	2019.09.27	7/15/2019
41	Шинээр үүсэх гэр хорооллын цахилгааны зураг	2019.10.25	10/28/2019
42	Боржигин чуулгын холболтын зураг	2019.10.25 2019.11.21	10/28/2019
43	Аймгийн төвийн авто замын зураг /1.4 км/	2019.11.06	10/28/2019
44	Нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2019.07.02	7/1/2019
45	Нийтийн эзэмшлийн орон сууцны 2-р байрны подвалын шугам сүлжээний их засвар	2019.04.02	2/18/2019
46	Нийтийн эзэмшлийн орон сууцны 121-127-р байрны дээврийн хэсэгчилсэн засвар, авто зогсоол байгуулах ажил	2019.05.17	2/19/2019
47	5-р сургуулийн спорт заалны шалны засварын ажил	2019.06.03 2019.06.10 2019.08.23	2/22/2019
48	6 дугаар цэцэрлэгийн гадна хашаа барих ажил	2019.03.22	3/11/2019
49	Өрхийн эмнэлэгт авто машин худалдан авах	2019.03.14	2/20/2019